

Монголбанкны Ерөнхийлөгч, Санхүүгийн
зохицуулах хорооны дарга, Сангийн сайдын
2010 оны 4 дүгээр сарын ... дугаар тушаалын
1 дүгээр хавсралт

ТӨСӨЛ

*/Зөвлөлийн 2010 оны 4 дүгээр сарын 05-ны өдрийн
хуралдааны шийдвэрийг тусгасан/*

САНХҮҮГИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАХ ДҮРЭМ

НЭГ. Нийтлэг үндэслэл

- 1.1. Монголбанк, Санхүү эдийн засгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага /цаашид Сангийн яам гэх/, Санхүүгийн зохицуулах хороо хамтран байгуулсан Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл /цаашид Зөвлөл гэх/-ийн бүтэц, зохион байгуулалт, санхүүгийн тогтвортой байдлыг хангах чиглэлээр талуудын оролцоо, үүргийг тодорхойлж, ажлын уялдаа холбоог тогтооход энэхүү дүрмийн гол зорилго оршино.
- 1.2. Зөвлөл энэ дүрмийн 2.1-д заасан зорилго, санхүүгийн салбарын холбогдох Монгол Улсын хууль, түүнд нийцүүлэн гаргасан хууль тогтоомж, талуудын хооронд байгуулсан харилцан ойлголцлын санамж бичгийн хүрээнд чиг үүргээ хэрэгжүүлнэ.

ХОЁР. Зөвлөлийн зорилго, үйл ажиллагааны зарчим

2.1. Санхүүгийн салбарын зохистой дэд бүтэц, банк санхүүгийн үйл ажиллагаанд тавих хяналтыг бэхжүүлэх, учирч болзошгүй санхүүгийн хямралаас урьдчилан сэргийлэх зэрэг санхүүгийн салбарын тогтвортой байдал ба төсөв, мөнгөний бодлогын уялдааг хангахад чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд талуудын үүрэг оролцоог тодорхойлох, тэдгээрийн хоорондын хамтын ажиллагааг уялдуулан зохицуулахад Зөвлөлийн гол зорилго оршино.

2.2. Монголбанк, Санхүү, төсвийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, Санхүүгийн зохицуулах хороо /цаашид Талууд/- байгуулсан Зөвлөл үйл ажиллагаагаа дараахь зарчмын дагуу хэрэгжүүлнэ:

2.2.1. Талуудын харилцан хүлээх үүрэг тодорхой, ил тод байх;

2.2.2. Талуудын чиг үүргийн давхардлыг бий болгохоос сэргийлэх;

2.2.3. Зөвлөлийн хамтарсан шийдвэрийн дагуу талууд чиг үүргээ хэрэгжүүлэхдээ тус тусын үйл ажиллагаанд оролцохгүй, хууль бусаар нөлөөлөхгүй байх;

2.2.4. Мэдээллийг харилцан байнга шуурхай солилцох.

ГУРАВ: Зөвлөлийн эрх, үүрэг

3.1. Зөвлөл нь Монголбанкны Ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнээс бүрдэнэ.

3.2. Зөвлөл нь энэ дүрмийн 2.1-д заасан зорилгыг хэрэгжүүлэхдээ дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

3.2.1. Монгол Улсын санхүүгийн тогтолцоо, түүний тогтвортой байдлыг хангах, түүнд сөргөөр нөлөөлж болзошгүй нөхцөл байдал үүссэн тохиолдолд дүн шинжилгээ хийж, түүнийг арилгах талаар Талуудаас авч хэрэгжүүлэх үйл ажиллагааг уялдуулан зохицуулах;

3.2.2. Санхүүгийн асуудлаар зөвлөмж, дүгнэлт, шийдвэр гаргаж Улсын Их Хурал, олон нийтэд мэдээлэх;

3.2.3. Банкны төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдийг нэр дэвшүүлэх, томилох, чөлөөлөх журмыг батлах, хяналт тавих;

3.2.4. Талуудаас санхүүгийн тогтвортой байдлыг хангах зорилгоор холбогдох хууль тогтоомжид тусгуулахаар төлөвлөж буй санхүүгийн тогтвортой байдлыг хангах бодлого, зохицуулалтыг хэлэлцэж, тохиролцох;

3.2.5. Санхүүгийн зах зээлийн бодлого, зохицуулалтын өөрчлөлт нь улс орны санхүүгийн тогтвортой байдалд хэрхэн нөлөөлж буйд судалгаа хийж, шаардлагатай тохиолдолд Талуудаас хамтран авч хэрэгжүүлэх арга хэмжээг хэлэлцэж шийдвэрлэх;

3.2.6. Санхүүгийн салбарын тогтвортой байдлыг бий болгох, эдийн засгийн өсөлтийг сэргээж, тогтворжуулахад чиглэсэн мөнгөний бодлогыг төсвийн бодлоготой уялдуулах асуудлаар холбогдох байгууллагад зөвлөмж гаргах;

3.2.7. Монголбанк, Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хорооны харилцан ойлголцлын санамж бичгийн хэрэгжилтэд хяналт тавьж, санамж бичгээр Талуудын хүлээсэн эрх үүргийг хэрэгжүүлэхэд үүсч буй тулгамдсан асуудлыг хэлэлцэж шийдвэрлэх, санамж бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах;

3.2.8. Санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах талаар гадаад орнуудаас авч хэрэгжүүлж буй арга хэмжээг судалж, өөрийн орны санхүүгийн зах зээлд нэвтрүүлэх санал боловсруулж шийдвэрлэх;

3.2.9. Монголбанк болон Санхүүгийн зохицуулах хорооноос хамтарч эрсдэл учирсан болон учирч болзошгүй санхүүгийн нэгдэлд шаардлагатай гэж үзвэл нэгдсэн хяналт шалгалт хийж, дүнг Зөвлөлд танилцуулж түүнтэй холбоотой Талуудаас авч хэрэгжүүлэх арга хэмжээг хэлэлцэж шийдвэрлэх;

3.2.10. Хямралын үед санхүү, эдийн засгийн тогтвортой байдал болон төсөв, мөнгөний бодлогын уялдааг хангах талаар эрх бүхий байгууллагуудаас авч хэрэгжүүлэх арга хэмжээг уялдуулах.

ДӨРӨВ: Зөвлөлийн хуралдаан ба хуралдааны дэг

4.1. Зөвлөлийн хуралдаан нь ээлжит болон ээлжит бус байна. Ээлжит хуралдаан улиралд нэгээс доошгүй удаа хуралдах бөгөөд ээлжит бус хуралдааныг аль ч Талын санаачилгаар хуралдуулж болно.

4.2. Зөвлөлийн хуралдааныг Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайд, Санхүүгийн зохицуулах хорооны дарга гэсэн дараалалаар хуралдаан хуралдаанаар ээлжилж даргална.

4.3. Ээлжит бус хуралдааныг санаачилсан тал зохион байгуулж, хурлыг даргална.

4.4. Зөвлөлийн гишүүд бүгд оролцсоноор хуралдаан хүчин төгөлдөр болно.

4.5. Зөвлөлийн хуралдаанд Зөвлөлийн гишүүд, Зохицуулагчид, асуудал хариуцсан мэргэжилтэн, Албаны дарга байнга оролцоно.

4.6. Зөвлөлийн хуралдааны шийдвэр Зөвлөлийн гишүүдийн 100%-ийн саналаар хүчин төгөлдөр болно.

4.7. Зөвлөл бүрэн эрхийнхээ хүрээнд зөвлөмж, дүгнэлт, шийдвэр гаргах бөгөөд тэдгээрт Талууд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.

4.8. Зөвлөл нь хэвлэмэл хуудастай байна.

4.9. Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн шийдвэрийг Талууд хуулиар олгогдсон бүрэн эрхийнхээ хүрээнд тогтоол, тушаал гарган баталгаажуулж, хэрэгжүүлнэ.

4.10. Зөвлөлийн гишүүд өөрийн харьяалал болон зохицуулалтын хүрээний асуудлаар Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэх асуудлын бэлтгэлийг хангах, Зөвлөлөөс баталсан шийдвэрийн биелэлтийг хариуцна.

4.11. Зөвлөлийн хуралдааны тэмдэглэлийг Ажлын албанаас хөтөлж, Албаны дарга гарын үсэг зурж баталгаажуулна. Тэмдэглэлд хэлэлцсэн асуудлын жагсаалт, холбогдох материалыг хавсаргасан байна.

4.12. Ажлын албаны дарга Зөвлөлийн хуралдааны даргын тогтоосон Зөвлөлийн хуралдааны товч Зөвлөл хуралдахаас ажлын 2 өдрийн өмнө Талуудад мэдэгдэж, хурлын материалыг урьдчилан тараасан байна.

4.13. Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг бэлтгэн оруулж буй Тал дараах материалыг Ажлын албаны даргад хуралдаан болохоос ажлын 4 өдрийн өмнө хүргүүлсэн байна:

4.13.1. Хэлэлцэх асуудлын талаар гарах шийдвэрийн төсөл;

4.13.2. Хэлэлцэх асуудлын товч танилцуулга;

4.13.3. Хэлэлцэх асуудлаас үүсч болох үр дүнгийн талаарх үнэлэлт, дүгнэлт;

4.13.4. Хэлэлцэх асуудлын талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний танилцуулга.

ТАВ: Ажлын албаны бүтэц, зохион байгуулалт

5.1. Зөвлөл нь Ажлын албатай байна. Ажлын алба нь нэг орон тоотой байна. Ажлын албаны дарга нь Зөвлөлийн өмнө нарийн бичгийн даргын үүргийг мөн гүйцэтгэнэ.

5.2. Ажлын алба Монголбанкны байранд байнгын үйл ажиллагаагаа явуулна.

5.3. Талууд санал нэгтгэйгээр ажлын албаны даргыг томилох бөгөөд тэрээр дараах эрх үүргийг хэрэгжүүлнэ:

5.3.1. Зөвлөлийн ээлжит болон ээлжит бус хуралдааны бэлтгэл ажлыг хангах, зохион байгуулах;

5.3.2. Санхүүгийн тогтвортой байдлын мэдээ мэдээллийг олон нийтэд мэдээлэх, хэвлэлийн бага хурал зохион байгуулах;

5.3.3. Зөвлөлийн үйл ажиллагааны төсөв, Зөвлөлийн дотоод үйл ажиллагааны журам, зөвлөмж, дүгнэлт, шийдвэрийн төсөл боловсруулж батлуулах;

5.3.4. Зөвлөлийн хуралдаанаас баталсан шийдвэрийн дагуу өгсөн бусад үүрэг, даалгаврыг биелүүлэх;

5.3.5. Шаардлагатай гэж үзвэл тухайн салбараар мэргэшсэн зөвлөх, эрдэмтэн судлаачдыг авч ажлуулж болно.

5.4. Зөвлөлийн гишүүд Зөвлөлөөс баталсан шийдвэрийн биелэлтийг хариуцан зохицуулах чиг үүргийг хэрэгжүүлэх газрын дарга/орлогч (Монголбанкны хувьд газар/хэлтсийн захирал)-оос доошгүй нэг албан тушаалтныг Зөвлөлийн ажлын албаны Зохицуулагчаар тус тус томилно.

5.5. Зохицуулагчид Зөвлөлийн ажлын албанаас өгсөн үүрэг, даалгаврыг өөрийн үндсэн ажил үүрэгтэйгээ хавсран гүйцэтгэх бөгөөд тэр нь орон тооны бус байна.

5.6. Зохицуулагчийн ажил хавсран гүйцэтгэсний нэмэгдэл цалин хөлс, урамшуулал ба түүнтэй холбоотой хөдөлмөрийн эрх зүйн асуудлыг тухайн Зохицуулагчийг томилсон Зөвлөлийн гишүүн хариуцна.

5.7. Зохицуулагчид ажлын албаны даргаас өгсөн чиглэлийн дагуу дараах эрх үүргийг хэрэгжүүлнэ:

5.7.1. Зөвлөлийн хуралдаанд шаардлагатай бол оролцох, түүний бэлтгэл ажлыг хангах;

5.7.2. Зөвлөлийн хуралдаан болон түүний үйл ажиллагаатай холбогдох баримт бичгийг боловсруулах, нэгтгэх, хадгалах;

5.7.3. Ажлын албаны даргад өөрийн байгууллагын зүгээс Зөвлөлийн хуралдаанд оруулах асуудал, холбогдох баримт бичгийг хүргүүлэх.

5.7.4. Зөвлөлийн хуралдаанаас баталсан шийдвэрийг биелүүлэхэд шаардлагатай бусад арга хэмжээг Ажлын албанаас өгсөн чиглэлийн дагуу зохицуулах, зохион байгуулах.

ЗУРГАА: Бусад

6.1. Зөвлөлийн үйл ажиллагааны болон Зөвлөлөөс гаргасан шийдвэр, бусад мэдээ, мэдээллийг гишүүд зөвхөн Зөвлөлийн зөвшөөрлөөр олон нийтэд болон бусад мэдээлнэ.

6.2. Зөвлөл, түүний Ажлын албаны үйл ажиллагааны жилийн тосов, түүний бүрдүүлэлт, зарцуулалтын хэлбэрийг Зөвлөлийн хуралдаанаар батална.

6.3. Зөвлөл, түүний Ажлын албаны жилийн үйл ажиллагааны зардлыг бүрдүүлэхдээ Талууд ижил тэнцүү зарчмыг баримтлан оролцоно.

Монголбанкны Ерөнхийлөгч, Санхүүгийн
зохицуулах хорооны дарга, Сангийн сайдын
2010 оны ... дугаар сарын ... дугаар тушаалын
Хавсралт 2

